

ХУРААНГУЙ

Эрүүл мэндийн сайдын 2014 оны 01 сарын 13-ны 13 дугаар тушаалаар “Хэрэглэгчийн сэтгэл ханамжийн судалгааны аргачлал” батлагдсан. Энэ дагуу хэрэглэгчийн сэтгэл ханамжийн судалгааг аймагт, аймгийн Эрүүл мэндийн газар зохион байгуулахаар даалгаж, судалгааны аргачлалд сэтгэл ханамжийн судалгааг (хэрэглэгчийн үнэлгээ) тухайн оны гүйцэтгэлийн хяналт шинжилгээ, үнэлгээний тайлангийн хамт ЭМЯ-ны (хуучнаар) ХШҮДА-ын газарт ирүүлэхийг заасан байна.

байдал, удирдлага зохион байгуулалт, тэгш байдал, ашиг сонирхол гэсэн 5 дэд бүлэг бүхий 35-39 хэмжигдэхүүн бүхий асуулгаар.,

Эмч, эмнэлгийн мэргэжилтэн, ажилтны сэтгэл ханамжийг дэмжлэгт удирдлага, хүний нөөцийн хөгжих боломж, эмнэлгийн мэргэжилтний ёс зүй, үйлчилгээний соёл, байгууллагын соёл, тусламж Амбулаторын үйлчлүүлэгчид, хэвтэн эмчлүүлэгчдийн сэтгэл ханамжийг байгууллагын соёл, эмнэлгийн мэргэжилтний ёс зүй, үйлчилгээний соёл, тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй, үйлчилгээний чанар, аюулгүй байдал, ажлын байрны аюулгүй дэмжлэгт орчин гэсэн 6 дэд бүлэг бүхий 46 хэмжигдэхүүн бүхий асуулгаар тус тус судалгааг авахаар, байгууллагын онцлогтой уялдан асуулт нэмэх, хасах, шинэчлэх нь нээлттэй байхаар арга зүйд тусгасан байна.

Энэ аргачлалын дагуу 21 аймаг, нийслэлийн 9 дүүргийн 25 эрүүл мэндийн байгууллага, нийт 46 байгууллага хэрэглэгчийн сэтгэл ханамжийн судалгаа авч, нэгтгэн, үр дүнгийн тайлангаа ирүүлсэн.

Эрүүл мэндийн байгууллагууд нь судалгаа хийхдээ ЭМСайдын 2014 оны 13 дугаар тушаалын хавсралтаар баталсан нэгдсэн асуумжийн дагуу жигд аваагүй, мэдээлэлд боловсруулалт хийхдээ нэгдсэн аргачлалыг баримтлаагүйгээс нэгтгэл хийхэд тодорхой бэрхшээлүүд тулгарсан ба боломжит бүх үр дүнгүүдийг авч нэгтгэн, боловсруулалт хийлээ.

Судалгаанд 21 аймгийн эмч, эмнэлгийн мэргэжилтэн, эрүүл мэндийн байгууллагуудын амбулаториор үйлчлүүлэгч, хэвтэн эмчлүүлэгч 50743, нийслэлийн 16 эрүүл мэндийн байгууллагуудын амбулаториор үйлчлүүлэгч, хэвтэн эмчлүүлэгч 29566, нийт 80390 хүн хамрагдсан байна.

Байгууллагуудаас ирсэн тайлангаас боломжит бүх үр дүнгүүдийг авч нэгтгэн дүгнэхэд амбулаторын нийт үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамжийн түвшин 78.4%, хэвтэн эмчлүүлэгчдийн сэтгэл ханамжын түвшин 82.2%, эмч, эмнэлгийн ажилчдын сэтгэл ханамжын түвшин 76.9% байна.

Судалгаанд хамрагдсан 80309 хүний ерөнхий сэтгэл ханамжийн дүнг нэгтгэн үзэл, нийлбэр дунджаар 79.9%-тай байна.

Хэрэглэгчийн сэтгэл ханамжийн судалгааны давтамж нь байгууллага бүрд харилцан адилгүй, хамрагдах шаардлагатай субъектуудыг бүрэн хамруулаагүй, эсвэл ялгах боломжгүй байдлаар үр дүнг тайлагнасан байна.

Цаашид ЭМСайдын 2014 оны 13 дугаар тушаалаар батлагдсан аргачлалаар, үнэн магадлалыг хангасан түүвэрлэлтийн дагуу судалгааг хийх, мэдээллийг боловсруулах, тайлагнах, судалгааны давтамжийг тодорхой болгох, судалгаанд үндэслэн авч хэрэгжүүлсэн арга хэмжээг тайлагнах, судалгааны үр дүнг жилийн эцсийн үнэлгээнд хэрхэн ашиглах талаар нэгдсэн ойлголт, арга зүйгээр хангах, сургалтууд зохион байгуулах хэрэгцээ шаардлага байна.

НЭГ. АЖЛЫН ҮНДЭСЛЭЛ

Эрүүл мэндийн байгууллагын жилийн үйл ажиллагааны гүйцэтгэлийг үнэлэх ажлын нэг үзүүлэлт нь хэрэглэгчийн сэтгэл ханамжийн судалгааны үнэлгээ байдаг.

Энэ ажлын хүрээнд Эрүүл мэндийн сайдын 2014 оны 01 сарын 13-ны өдрийн 13 тоот тушаалаар “Хэрэглэгчийн сэтгэл ханамжийн судалгааны аргачлал” батлагдан, эрүүл мэндийн байгууллагууд нэгдсэн аргачлал, асуулгаар судалгаа хийх боломж бүрдсэн.

Энэхүү тушаалаар аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газар нь хэрэглэгчийн сэтгэл ханамжийн судалгааг харьяа байгууллагууддаа зохион байгуулан, хэрэглэгчийн үнэлгээг тухайн оны гүйцэтгэлийн хяналт шинжилгээ, үнэлгээний тайлангийн хамт ЭМЯ-ны (хуучнаар) ХШҮДА-ын газарт ирүүлэхээр заасан байна.

Энэ дагуу аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газар хэрэглэгчийн судалгааны үр дүнгийн тайлангаа ирүүлсэнийг нэгтгэн, дүгнэлт, зөвлөмж гаргах нь энэхүү ажлын үндэслэл болж байна.

Ажлын зорилго: Аймаг, нийслэлийн Хэрэглэгчийн сэтгэл ханамжийн судалгааны нэгтгэл хийж, дүгнэлт, зөвлөмж боловсруулах

Зорилт:

- Нийслэл, аймгийн хэрэглэгчийн сэтгэл ханамжийн судалгааны үр дүнгийн тайланг нэгтгэн, нэгдсэн дүгнэлт зөвлөмж гаргах
- Нийслэл, аймаг, бүрээр дүгнэлт, зөвлөмж гаргах

Үр дүн: Нийслэл, аймгийн хэрэглэгчийн сэтгэл ханамжийн судалгааны нэгдсэн нэгтгэл хийгдэж, үр дүнгийн тайлан бичигдэж, эрүүл мэндийн байгууллагуудыг нэгдсэн дүгнэлт зөвлөмжөөр хангана.

Хугацаа: 2016.02.18 - 2016.02.28

Ажиллах хүчин: Эрүүл мэндийн хөгжлийн төвийн Судалгаа, төлөвлөлт, статистик мэдээллийн албаны мэргэжилтнүүд

ХОЁР. СУДАЛГААНЫ ҮР ДҮН

2.1. АЙМГИЙН ХЭРЭГЛЭГЧИЙН СЭТГЭЛ ХАНАМЖИЙН СУДАЛГААНЫ ҮР ДҮН

Архангай аймаг: Судалгаанд нийт 192 хэвтэн эмчлүүлэгч хамрагдснаас 44.1% нь эрэгтэй, 55.9% нь эмэгтэй үйлчлүүлэгч, 48.4% нь анх удаа хэвтэн үйлчлүүлж байгаа, 51.6% нь 2 ба түүнээс дээш удаа хэвтэн үйлчлүүлж байгаа иргэд байна. Амбулаторын үйлчлүүлэгч 779 иргэн судалгаанд хамрагдснаас 38.6% нь эрэгтэй, 61.1% нь эмэгтэйчүүд байсан. 39.5% нь анх удаа, 59.9% нь 2 ба түүнээс дээш удаа үйлчлүүлж байгаа иргэд байна.

Нийт 242 эмч, эмнэлгийн мэргэжилтэн, ажилтан хамрагдсан байна. Үүнээс 14.6% нь их эмч, 23.2% нь сувилагч, 8.6% нь бага эмч, 3.4% нь эх баригч бага эмч, 9.7% нь багийн бага эмч, 36.8% нь бусад ажилчид байна.

Дүгнэлт: ЭМЯ-ны 2014 оны 13-р тушаалын дагуу судалгааг эмнэлгийн ажилчдын, амбулаториор үйлчлүүлэгчдийн, хэвтэн эмчлүүлэгчдийн 3 чиглэлээр хийж нэгтгэлийг эксел файлаар ирүүлсэн ба судалгаанд оролцогчдын ерөнхий мэдээллээс өөр ямар нэг дүгнэлт хийгээгүй байна.

Зөвлөмж:

- Судалгааг тодорхой үечлэлтэй хийж хэвших
- Үр дүнг харьцуулж, өөрчлөлтийг харах
- Дүгнэлтэд үндэслэн үйл ажиллагааг сайжруулах талаар арга хэмжээ зохион байгуулах
- Томоохон өөрчлөлт хийх арга хэмжээг төлөвлөлтөндөө тусгаж ажиллах

Баян-Өлгий аймаг: Судалгаанд нийт 19 эрүүл мэндийн байгууллагын 3750 эмч, эмнэлгийн ажилчид, үйлчлүүлэгчид хамрагдсан. Сэтгэл ханамжийн судалгааг үйлчлүүлэгчдээс сар болгон, эмч эмнэлгийн мэргэжилтнээс улирал бүр авч, судалгааны дүгнэлтэд үндэслэн, эрүүл мэндийн байгууллагуудын гадаад, дотоод орчин сайжруулах, эмч, эмнэлгийн мэргэжилтний ёс зүй, ур чадварыг дээшлүүлэх, эмнэлгийн тусламж үйлчилгээний чанар сайжруулах гэсэн 3 үндсэн чиглэлээр 170 ажлыг хэрэгжүүлж ажилласан байна.

Дүгнэлт: Судалгааны тоон үзүүлэлтийг ирүүлээгүй, судалгааны мөрөөр хийсэн ажлуудыг жагсаан бичсэн байна.

Зөвлөмж:

- Судалгааны давтамжийн тоон үзүүлэлтийг харьцуулсан дүрслэлийг тайланд харуулах
- Судалгааны 3 чиглэлд бүрт хамрагдсан хүмүүсийн тоог тайланд тодорхой тусгах
- Хэрэгжүүлсэн ажлуудыг судалгааны ямар дүгнэлтэнд үндэслэн хэрхэн төлөвлөж ажилласан талаар тодруулах

Баянхонгор аймаг: Судалгаанд аймгийн нэгдсэн эмнэлэг, 3 сум дундын эмнэлэг, 17 сумын эрүүл мэндийн төв, 5 өрхийн эрүүл мэндийн төвийн нийт 593 эмч, эмнэлгийн мэргэжилтэн/их эмч-80, эмнэлгийн мэргэжилтэн-280, бусад ажилтан-233/, нийт 787 үйлчлүүлэгчээс 592 нь амбулаториор, 195 нь хэвтэн эмчлүүлэгч хамрагдсан байна.

Дүгнэлт: Судалгааг ЭМЯ-ны 2014 оны 13-р тушаалын дагуу харьяа эрүүл мэндийн байгууллагуудыг хамруулж түүвэрлэлтийг хийж судалгааг дүгнэсэн байна. Нийт эерэг сэтгэл ханамжийн байдал 81.6 хувьтай үнэлэгдэж, /2014 оны судалгааны эерэг сэтгэл ханамж 80.3/ 1.6 хувиар иргэдийн сэтгэл ханамжийн эерэг байдал нэмэгдсэн байна.

Зөвлөмж:

- Судалгааг үечлэлтэй хийж үр дүнг харьцуулж байх
- Судалгааны үр дүнд үндэслэн дэвшүүлсэн саналыг үйл ажиллагаанд төлөвлөн тодорхой арга хэмжээ авсан байх
- Төлөвлөсөн ажлын дагуу гарсан үр дүнг тайланд тодруулах

АЙМАГ, НИЙСЛЭЛИЙН МЭНДИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН ХЭРЭГЛЭГЧДИЙН СЭТГЭЛ ХАНАМЖ

Булган аймаг: Судалгааг нийт 17 сумын иргэдээс улирал тутам авч, нийт Эрүүл мэндийн байгууллагуудаар үйлчлүүлж буй 4889 үйлчлүүлэгч, үүнээс 2966 нь хэвтэн эмчлүүлэгч, 1923 нь амбулаториор үйлчлүүлэгч, 295 эмч, эмнэлгийн мэргэжилтэнг хамруулсан байна.

Судалгааг улирал бүр хийж, дүгнэлтэнд үндэслэн сэтгэл ханамжийн үзүүлэлтийг улам сайжруулах талаар Эрүүл мэндийн байгууллагуудад зөвлөмж хүргүүлэн, үйл ажиллагааг эрчимжүүлэх ажлын төлөвлөгөө гарган ажилласан байна. Судалгааны үр дүнг сүүлийн 3 жилээр харьцуулсан зураглалаас харахад сэтгэл ханамж сайн гэсэн үнэлгээ 2013 онд 47.8%, 2014 онд 42.5%, 2015 онд 61.5% болж өссөн байна.

Дүгнэлт: Судалгааны дүгнэлтэнд үндэслэн авсан арга хэмжээ авч, хэрэгжүүлсэн ажлаа тайлагнаагүй байна.

Зөвлөмж:

- Улирал бүр хийсэн судалгааг нэгтгэн жилийн эцсийн үнэлгээний тоон үзүүлэлтийг тодруулж гаргах
- Дүгнэлтэд үндэслэн үйл ажиллагааг сайжруулах талаар арга хэмжээ зохион байгуулах
- Томоохон өөрчлөлт хийх арга хэмжээг төлөвлөлтөндөө тусгаж ажиллах

Говь-Алтай аймаг: Судалгааг 2015 онд харьяа 12 байгууллага, 223 эмч, эмнэлгийн мэргэжилтэн, 496 хэвтэн эмчлүүлэгч, 1069 амбулаториор үйлчлүүлэгчээс авч, сэтгэл ханамжийн судалгааны мэдээлэлд боловсруулалт хийх зааврын дагуу нэгтгэн дүгнэсэн байна.

Дүгнэлт: 2014 оны сэтгэл ханамжийн судалгааны тайлангийн зөвлөмжийг харьча эрүүл мэндийн байгууллагуудад хүргүүлсэн байна. Судалгааг хийсэн байгууллагын тоо байгаа боловч ямар ямар байгууллага болох нь тодорхой бус байна. Гаргасан тоон үзүүлэлтийн дүгнэлт, харьцуулалт үгүй байна.

Зөвлөмж:

- Судалгааг үечлэлтэй хийж үр дүнг харьцуулж байх
- Судалгааны үр дүнд үндэслэн дэвшүүлсэн саналыг үйл ажиллагаанд төлөвлөн тодорхой арга хэмжээ авсан байх
- Төлөвлөсөн ажлын дагуу гарсан үр дүнг тайланд тодруулах

Говьсүмбэр аймаг: Судалгаанд насанд хүрсэн иргэдийн 3 хувь буюу 288 хэвтэн эмчлүүлэгчид, амбулаторын үйлчлүүлэгчээс сэтгэл ханамжийн судалгааг авч нэгтгэсэн байна. Хэрэглэгчдийн ерөнхий сэтгэл ханамж сайн 78,8%, дунд 15,9%, муу 5,3% байлаа гэсэн нэг дүгнэлттэй. Амбулатори, хэвтэн эмчлүүлэх, болон эмнэлгийн ажилчдын судалгааны задаргаа дүгнэлтгүй, ихэнхдээ судалгааг авсан аргачлалын талаар дурьдсан байна.

Дүгнэлт: Судалгааны тайланг ЭМЯ-ны 2014 оны 13-р тушаалын дагуу эмнэлгийн ажилчдын, амбулаториор үйлчлүүлэгчдийн болон хэвтэн эмчлүүлэгчдийн 3 чиглэлээр хийж нэгтгээгүй, ганцхан дүгнэлттэй ирүүлсэн байна.

Зөвлөмж:

- Судалгааг тодорхой үечлэлтэй хийж хэвших
- Үр дүнг харьцуулсан тайлан бичих
- Үр дүнг харьцуулан харах үүднээс нэг агшинд хамрагдсан хүний тоо, хэдэн сарын тутамд авсаныг тайландаа оруулах
- Судалгааны дүгнэлтэнд үндэслэн үйл ажиллагааг сайжруулах талаар арга хэмжээ зохион байгуулах ажлуудыг төлөвлөлтөндөө тусгах
- Судалгааг аргачлалын дагуу задалж, дүгнэх

Дархан аймаг: Амбулатороор үйлчлүүлэгчдийн судалгааг нэгдсэн эмнэлгийн амбулатори, Өрхийн 5 эмнэлэг, сумын 3 эмнэлгийн амбулатороор 320 үйлчлүүлэгчдээс авсан судалгаагаар дүгнэсэн. Эрүүл мэндийн салбарын хэмжээнд амбулаторын үйлчилгээний нэгдсэн дүнг үзэхэд 78.1% сайн, 13.4% дунд, 8.5% нь хангалтгүй гэж үнэлсэн байна. Стационарт хэвтүүлэн эмчилүүлэгчдийн судалгааг Амбулатороор нэгдсэн эмнэлгийн тасгууд, Шарын гол, Орхон, Хонгор сумын эрүүл мэндийн төвүүдийн 180 үйлчлүүлэгчдээс авсан. Стационарын үйлчилгээний нэгдсэн дүнг үзэхэд 81.6% сайн, 9.6% дунд, 8.8% нь хангалтгүй гэж үнэлсэн байна.

Эмч, эмнэлгийн ажилчдын сэтгэл ханамжийн судалгааг НЭМТ, нэгдсэн эмнэлгийн бүх тасаг нэгжүүд, 5 өрх, 3 сумын эрүүл мэндийн төвийн 230 эмч, ажилчдаас авч дүгнэсэн. Судалгааны нэгдсэн 82.4% сайн, 14.2% дунд, 3.4% нь хангалтгүй гэж үнэлсэн байна. Үнэлгээнээс хамгийн бага буюу 71.2% үнэлгээтэй нь ажлын байрны аюулгүй дэмжлэгт орчин ба дэмжлэгт удирдлага 79.1%, хүний нөөцийн хөгжих боломж 74.7%, тусламж үйлчилгээний чанар, аюулгүй байдалд эмч эмнэлгийн мэргэжилтнүүдийн 22%, байгууллагын соёлд 25.6% нь сэтгэл ханамжгүй гэж дүгнэсэн байна.

Дүгнэлт: Тус аймаг нь судалгааг 2 удаа авч, дүгнэлтийг амбулатори, хэвтэн эмчлүүлэх, эмч, эмнэлгийн ажилчдын сэтгэл ханамж гэж 3 хувааж тус бүрийг задаргаа, тайлбар болон дүгнэлттэй нь бичсэн байна. Судалгааны үзүүлэлт болгоны эцэст болон нэгдсэн дүгнэлтэнд хэрэгжүүлэх үйл ажиллагааны талаар дурьдсан байна. Мөн судалгааг үечлэлтэй авсан боловч үр дүнгээ харьцуулсан дүгнэлт гаргаж бичээгүй байна.

Зөвлөмж:

- Үр дүнг харьцуулсан тайлан бичих
- Үр дүнг харьцуулан харах үүднээс нэг агшинд хамрагдсан хүний тоо, хэдэн сарын тутамд авсаныг тайландаа оруулах
- Судалгаанаас үндэслэсэн анхааран ажиллах ажлуудыг төлөвлөлтөндөө оруулах

Дорноговь аймаг: Дорноговь аймгийн 453 иргэн энэхүү судалгаанд хамрагдсан. Судалгааг нийт 22 байгууллагын үйлчлүүлэгчээс авч асуумж болгоны задаргааг дүрслэлээр үзүүлсэн дүгнэлт бичсэн. Энэ дүгнэлтэд эмнэлгийн ажилчдын сэтгэл ханамжийн судалгааны дүнг оролцуулаагүй. Дүгнэлтийн эцэст цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар онцолж бичсэн байна.

Дүгнэлт: Судалгааны үзүүлэлтүүдийн задаргааг сайн бичсэн боловч амбулатори, хэвтэн эмчлүүлэх гэж ялгалгүй нэгтгэсэн байна. Мөн судалгааг хэдэн удаа авсан, тухайн агшинд хамрагдсан хүний тоог тайланд оруулаагүй байна.

Зөвлөмж:

- Тайланд амбулатори, хэвтэн эмчлүүлэх тасаг, эмнэлгийн ажилчдын гэж 3 хувааж дүгнэлтүүдийг нэгтгэх
- Судалгааг үечлэлтэй хийж хэвших, хамрагдсан хүний тоог тодруулан бичих
- Судалгааны дүгнэлтэнд үндэслэн үйл ажиллагааг сайжруулах талаар арга хэмжээ зохион байгуулах ажлуудыг төлөвлөлтөндөө тусгаж, үр дүнг харьцуулсан тайлан бичих

Дорнод аймаг: Аймгийн хэмжээнд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлж буй БОЭТ, УАУТ, сум дундын эмнэлэг, сумын эрүүл мэндийн төвүүд, өрхийн эрүүл мэндийн төвүүд нийт 18 байгууллагаар үйлчлүүлсэн 4125 хүнээс сэтгэл ханамжийн судалгааг авсан ба энэ нь Дорнод аймгийн нийт хүн амын 5,5 хувийг эзэлж байна. Үйлчлүүлэгчдийн ерөнхий сэтгэл ханамж 87 хувь нь сайн, 13 хувь нь дунд муу үнэлгээ өгсөн байна.

Дүгнэлт: Тус аймаг нь судалгааг улирал тутам авч, дүгнэлтийг амбулатори болон хэвтэн эмчлүүлэгч гэж ялгалгүй нэгтгэсэнээс гадна эмнэлгийн ажилчдын сэтгэл ханамжийн судалгааны дүнг оролцуулаагүй байна. Судалгааны дүгнэлтэнд сэтгэл ханамжийг дээшлүүлэх чиглэлээр хийх ажлыг байгууллагын үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусган хэрэгжилтийг ханган ажилласан гэж бичсэн байна.

Зөвлөмж:

- Тайланд амбулатори, хэвтэн эмчлүүлэх тасаг, эмнэлгийн ажилчдын гэж 3 хувааж дүгнэлтүүдийг нэгтгэх
- Судалгааг үечлэлтэй хийж хэвших
- Үр дүнг харьцуулсан тайлан бичих
- Үр дүнг харьцуулан харах үүднээс нэг агшинд хамрагдсан хүний тоо, хэдэн сарын тутамд авсаныг тайландаа оруулах

Дундговь аймаг: Тус аймаг нь тушаалын дагуу давхардсан тоогоор 876 эмч, эмнэлгийн ажилчид, 6720 үйлчлүүлэгчээс (амбулаторын 4240, хэвтэн эмчлүүлэгч 2480) сэтгэл ханамжийн судалгааг сар бүр авсан

АЙМАГ, НИЙСЛЭЛИЙН МЭНДИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН ХЭРЭГЛЭГЧДИЙН СЭТГЭЛ ХАНАМЖ

байна. Эхний хагас жилийн ерөнхий сэтгэл ханамж: сайн-69%, дунд-26,4%, муу-4.6% гэсэн үнэлгээ өгсөн байна.

Сэтгэл ханамжийн судалгааны дүнг үндэслэн, байгууллагын соёл, эмч, эмнэлгийн ажилчдын үйлчлүүлэгчдэд сэтгэлд нийцсэн үйлчилгээг үзүүлэхэд анхаарч үйлчилгээ, удирдлагыг сайжруулах 30 ажлуудыг хийгдсэнийг онцолсон. Эдгээр ажлын үр дүнд, сүүлийн хагас жилийн (давтан 3360 үйлчлүүлэгчдээс) нэгдсэн дүгнэлтээр ерөнхий сэтгэл ханамж сайн-87.2%, дунд-14.3%, муу-1.5% болж өмнөх хагас жилийн үйлчлүүлэгчдийн “сайн” үнэлгээ байгууллагын соёлд 4.7%-иар, эмч, эмнэлгийн мэргэжилтний ёс зүй, үйлчилгээний соёлд 3.6%-иар, удирдлага, зохион байгуулалтанд 4.8%-иар, ерөнхий сэтгэл ханамж 3%-иар өссөн үзүүлэлттэй гэж гарсан.

Дүгнэлт: Тус аймаг нь судалгааг улирал бүр тогтсон тоогоор авсан ба үзүүлэлтүүдэд дүгнэлт өгч, цаашид авч хэрэгжүүлэх шаардлагатай ажлын хэрэгцээг тогтоон ажилласан байна. Мөн нэгтгэлдээ эхний болон сүүлийн хагас жилийн судалгааны үр дүнг харьцуулан гаргасан байна. Гэвч судалгааны дүгнэлтийг амбулатори, хэвтэн эмчлүүлэгч гэж ялгалгүй нэгтгэсэн байна.

Зөвлөмж:

- Тайланд амбулатори, хэвтэн эмчлүүлэх тасаг, эмнэлгийн ажилчдын гэж 3 хувааж дүгнэлтүүдийг нэгтгэх
- Эхний хагас жилд задаргааг сайн гарган бичсэн байна. Харин сүүлийн хагас жилтэй харьцуулахад задаргааг сайн гаргаж бичээгүй учраас үр дүнг ижилхэн байдлар харьцуулан бичих

Завхан аймаг: Судалгаанд 58 их эмч, сувилагч, тусгай мэргэжилтэн 309, нийт 1684 хүн хамрагдсан байна. Судалгаанд оролцогчдын эрэгтэй 25% /421/, эмэгтэй 75% /1263/ байна. Судалгааг Эрүүл мэнд, спортын сайдын баталсан аргачлалын дагуу явуулж, дүнг нэгтгэсэн байна. Судалгааны дүгнэлтэд хэрэглэгчдийн сэтгэл ханамжийн судалгааг тодорхой давтамж үе шаттай зохион байгуулж, үйл ажиллагааны динамик, сайжралт, өөрчлөлтийг харьцуулах нь зүйтэй гэж үзсэн байна.

Дүгнэлт: Тайландаа судалгаанд оролцсон хүний тоо, хамрагдсан хүнийг сонгосон аргачлалыг сайн гаргаж бичсэн байна. Судалгааны аргачлалын дагуу амбулатори, хэвтэн эмчлүүлэх, эмнэлгийн ажилтан гэж 3 хувааж, тус бүрийн үзүүлэлтийг задаргаатай нь тайландаа оруулсан байна. Мөн сэтгэл ханамжийн судалгааны үр дүнд үндэслэн хийх ажлуудыг жагсааж, дүгнэлтээ сайн бичсэн байна.

Зөвлөмж:

- Судалгааг үечлэлтэй авах мөн авсан бол тайландаа тусган бичих
- Үечлэлтэй авсан судалгаануудыг харьцуулалт гарган бичих

Орхон аймаг: Аймагас ирүүлсэн судалгааны тайланд “Орхон аймгийн эрүүл мэндийн байгууллагуудаас сэтгэл ханамжийн судалгааг 46 байгууллагын тасаг нэгжээс авах хуваарь гарган ЭМС-ын 2014 оны 13-р тушаалын нэгдсэн асуумжаар сар бүр судалгааг авч дүгнэн, авсан арга хэмжээ, тулгамдсан асуудлаа шийдвэрлэн ажиллалаа” гэжээ. Судалгаанд 640 эмч, эмнэлгийн ажилтан хамрагдсан байна. Сэтгэл ханамжийн судалгааны дагуу арга хэмжээг авч ажилласан талаар дэлгэрэнгүй ирүүлсэн байна.

Дүгнэлт: Сэтгэл ханамжийн судалгааг хэрхэн үе шаттай авсан болон хамрагдсан хүний тоог бичээгүй. Тайланд судалгааны дүгнэлтүүдийг товчхон дурьдаж бичсэн бөгөөд үр дүнд хийсэн арга хэмжээний талаар дэлгэрэнгүй бичсэн нь харьцуулалт хийхэд хүндрэлтэй байдал үүсгэсэн. Мөн амбулатори, хэвтэн эмчлүүлэх, эмнэлгийн ажилчдын задаргаа байхгүй, товч нэгтгэсэн дүгнэлт бичсэн байна.

Зөвлөмж:

- Судалгааг тодорхой үечлэлтэй хийж хэвших
- Үр дүнг харьцуулсан тайлан бичих
- Үр дүнг харьцуулан харах үүднээс нэг агшинд хамрагдсан хүний тоо, хэдэн сарын тутамд авсаныг тайландаа оруулах
- Батлагдсан асуумжны аргачлалаар хийсэн эсэхийг тайландаа оруулах
- Амбулатори, хэвтэн эмчлүүлэх, эмнэлгийн ажиллагсдын гэж 3 хувааж тус бүрт нь дүгнэлтүүдийг задаргаатай нь гаргаж бичих

Өвөрхангай аймаг: Сэтгэл ханамжийн судалгааг нийт 2775 үйлчлүүлэгч /амбулаториор үйлчлүүлсэн 2165, хэвтэн эмчлүүлсэн 610/, эрүүл мэндийн салбарын 346 ажилтнаас сэтгэл ханамжийн судалгаа авсан байна.

Сэтгэл ханамжийн судалгааны мөрөөр авсан арга хэмжээний талаар дэлгэрэнгүй бичиж ирүүлсэн байна. Энэхүү үйл ажиллагаануудын үр дүнд 11 сарын байдлаар үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамж эхний хагас жилийн байдлаас 32.9 хувиар, эмч, эмнэлгийн ажилтны сэтгэл ханамж 10.2 хувиар дээшилсэн бөгөөд амбулаториор үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамж урд оноос 1.0 хувиар, хэвтэн эмчлүүлэгчдийн сэтгэл ханамж 18.7 хувиар өссөн байна. Судалгааг эхний хагас жил болон сүүлийн хагас жил гэж 2 удаагийн давтамжтай хийсэн байна. Сүүлийн хагас жилийн дүгнэлтийг нэгтгэсэн хүснэгтэнд оруулсан болно.

Дүгнэлт: Сэтгэл ханамжийн судалгааны үр дүнгийн дагуу авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаар дэлгэрэнгүй тайлан бичиж ирүүлсэн боловч сэтгэл ханамжийн судалгааны үр дүнгийн нэгдсэн хүснэгт хийгээгүй, судалгааны үр дүн ямар байсан талаар тодорхой мэдээлэл ирүүлээгүй байна.

Зөвлөмж:

- Судалгааг тодорхой үечлэлтэй хийж хэвших
- Үр дүнг харьцуулсан тайлан бичих
- Үр дүнг харьцуулан харах үүднээс нэг агшинд хамрагдсан хүний тоо, хэдэн сарын тутамд авсаныг тайландаа оруулах
- Батлагдсан асуумжны аргачлалаар хийсэн эсэхийг тайландаа оруулах

Өмнөговь аймаг: Өмнөговь аймаг 3 өөр байгууллагаас нэг аргачлалаар 3 удаа сэтгэл ханамжийн судалгааг авч дүнг нэгтгэн гаргасан байна. Нийт 2537 хүн судалгаанд хамрагдсан байна үүнээс эмч, эмнэлгийн ажилтан 920, үйлчлүүлэгч нь 1617 хүн байна. Үнэлгээнд эрүүл мэндийн байгууллагуудын өөрсдийн авсан сэтгэл ханамжийн судалгааны дүнг авч үнэлгээнд тавьсан.

Дүгнэлт: Өмнөговь аймгийн эрүүл мэндийн байгууллагуудын ажилтан, үйлчлүүлэгчдээс 3 өөр төрлийн байгууллагууд сэтгэл ханамжийн судалгааг авч судалгааны дүнг нэгтгэн дүгнэсэн нь давуу талтай болсон байна. Сэтгэл ханамжийн судалгааны үр дүнгийн дагуу арга хэмжээ авч ажилласан нь үр дүнтэй, оновчтой болсон байна.

Зөвлөмж:

- Үр дүнг харьцуулсан тайлан бичих
- Үр дүнг харьцуулан харах үүднээс нэг агшинд хамрагдсан хүний тоо, хэдэн сарын тутамд авсаныг тайландаа оруулах
- Батлагдсан асуумжны аргачлалаар хийсэн эсэхийг тайландаа оруулах

Сүхбаатар: Судалгаанд нийт 560 хүнээс авч, энгийн аргаар нэгтгэн дүгнэсэн байна. Судалгаанд оролцогчид нь асуудлыг хариулах, үнэлгээг өгөхдөө бүрэн дүүрэн гүйцэтгэж чадаагүй бөгөөд зарим тохиолдолд асуулганы 2-15 асуудлыг хариулаагүй орхисон байгаа нь судалгааны дүгнэлтийг үнэн зөв гаргахад бага боловч тодорхой хэмжээгээр нөлөөлсөн гэж үзсэн байна.

Эмч, эмнэлгийн сэтгэл ханамжийн судалгаанд 141 хүн оролцож, үүнээс 131 нь хариулсан, аймгийн нэгдсэн эмнэлэг, өрхийн болон сумын эрүүл мэндийн төвүүдийн амбулаториор нийт 275 үйлчлүүлэгчдийн 223 нь хариулсан, хэвтэн эмчлүүлэгчдийн 145 үйлчлүүлэгч оролцсоноос 126 үйлчлүүлэгч хариулсан байна гэж бичсэн.

Дүгнэлт: Судалгааны аргачлалын дагуу амбулатори, хэвтэн эмчлүүлэх, эмнэлгийн ажилтан гэж 3 хувааж дүгнэлт бичсэн ч задаргаа нь байхгүй байна. Мөн үр дүнд суурилсан саналуудын талаар дэлгэрэнгүй бичсэн ч цаашид хийх ажлуудын талаар бичээгүй байна. Тус тайлангын онцлог нь судалгааны асуумжны оновчтой байдал болон судалгаа авахад гарсан хүндрэлтэй нөхцлүүдийн талаар дүгнэлт гаргасан тайлан болсон байна.

Зөвлөмж:

- Судалгааг тодорхой үечлэлтэй хийж хэвших
- Үр дүнг харьцуулсан тайлан бичих

АЙМАГ, НИЙСЛЭЛИЙН МЭНДИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН ХЭРЭГЛЭГЧДИЙН СЭТГЭЛ ХАНАМЖ

- Үр дүнг харьцуулан харах үүднээс нэг агшинд хамрагдсан хүний тоо, хэдэн сарын тутамд авсаныг тайландаа оруулах
- Батлагдсан асуумжны аргачлалаар хийсэн эсэхийг тайландаа оруулах
- Амбулатори, хэвтэн эмчлүүлэх, эмнэлгийн ажиллагсдын гэж 3 хувааж тус бүрт нь дүгнэлтүүдийг задаргаатай нь гаргаж бичих
- Судалгааны дүгнэлтэнд үндэслэн үйл ажиллагааг сайжруулах талаар арга хэмжээ зохион байгуулах ажлуудыг төлөвлөлтөндөө тусгах

Сэлэнгэ аймаг: Сэлэнгэ аймгийн эрүүл мэндийн газраас авсан сэтгэл ханамжийн судалгаа нь Эрүүл мэнд, спортын сайдын 2014 оны 01 сарын 13-ны өдрийн 13 тоот тушаалын дагуу хийгдээгүй учраас нэгдсэн хүснэгтэнд бусад аймгуудтай харьцуулах боломжгүй байна.

Өөрсдийн гаргасан аргачлалын дагуу авсан судалгааны дүгнэлтээс харахад үйлчлүүлэгч нийт 565 хүн, 586 эмч, эмнэлгийн мэргэжилтэн хамрагдсан байна. Эмнэлгийн үйл ажиллагаа, үйлчилгээний чанарт 83% сайн, 16.5% дунд, 0.5% муу гэсэн дүнтэй, эмч ажилтнуудын харилцааны хандалагад 78% сэтгэл хангалуун, 19.2% танил тал харж үздэг, 2.8% гар харж үйлчилдэг гэжээ.

Дүгнэлт: Эрүүл мэнд, спортын сайдын баталсан аргачлалын дагуу судалгаагаа аваагүй байна. Судалгааны үр дүнгийн дагуу авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаар мэдээлээгүй байна.

Зөвлөмж:

- Эрүүл мэнд, спортын сайдын баталсан аргачлалын дагуу судалгаагаа авах
- Судалгааг тодорхой үечлэлтэй хийж хэвших
- Үр дүнг харьцуулсан тайлан бичих
- Үр дүнг харьцуулан харах үүднээс нэг агшинд хамрагдсан хүний тоо, хэдэн сарын тутамд авсаныг тайландаа оруулах
- Батлагдсан асуумжны аргачлалаар хийсэн эсэхийг тайландаа оруулах
- Амбулатори, хэвтэн эмчлүүлэх, эмнэлгийн ажиллагсдын гэж 3 хувааж тус бүрт нь дүгнэлтүүдийг задаргаатай нь гаргаж бичих

Төв аймаг: Тус аймаг нь судалгааны үр дүнгийн 2 хуудас мэдээлэл ирүүлсэн байна. Мэдээллээс харахад судалгаанд 14 сум, нэгдсэн эмнэлгээр үйлчлүүлсэн, 67 хэвтэн эмчлүүлэгч, 158 амбулаторын үйлчлүүлэгч, 246 эмч, эмнэлгийн мэргэжилтэн, ажилтан, нийт 471 хүн хамрагдсан байна.

ЭМГ-ын даргын 2014 оны 01.22-ны өдрийн 15 дугаар тушаалаар ажлын хэсэг байгуулагдан, ЭМС-ын 2014 оны 13 дугаар тушаалыг хэрэгжүүлж ажилласан байна. Төв аймгийн хэрэглэгчийн судалгаанд 15 байгууллагын 225 үйлчлүүлэгч, 246 эмч, мэргэжилтэн, ажилтан хамрагдсан байна. Мөн ирүүлсэн тайланд сумын эрүүл мэндийн төвийн чанарын багууд 222 удаа 4722 үйлчлүүлэгч, 9 удаа 210 эмч, эмнэлгийн ажилтнаас сэтгэл ханамжийн судалгаа авсан тухай дурдсан байна.

Төв аймаг нь улирал болгон судалгаа авснаар нэгтгэл ирүүлсэн боловч, түүвэрлэлтийн хэмжээ маш бага, тухайлбал 2 дугаар улиралд 29 хүнээс судалгаа авсан байгаа нь хангалтгүй үзүүлэлт юм. Амбулаторын сэтгэл ханамжийн судалгааны ерөнхий сэтгэл ханамж 77.9%тай, хэвтэн эмчлүүлэгчдийн сэтгэл ханамжийн ерөнхий сэтгэл ханамж 78.7%тай, эмч, эмнэлгийн мэргэжилтний ерөнхий сэтгэл ханамж 74.7% -тай, судалгаанд суурилан 11 асуудлыг шийдвэрлэсэн гэсэн байна.

Дүгнэлт: Судалгааг улирал тутам хийх гэсэн сайн тал харагдаж байгаа боловч, түүвэрлэлтийн тоо маш бага байна. Судалгааны үр дүнд тулгуурлан авсан арга хэмжээ тодорхой бус байна. Судалгааны түүврийг ямар эх олонлогоос хэрхэн хийсэн нь тодорхойгүй учир, судалгааны түүвэрлэлтийн тооны үнэн магадлалтай эсэхийг харах боломжгүй байна.

Зөвлөмж:

- Судалгааны түүвэрлэлтийн хэмжээг, аргачлалд тулгуурлан үнэн, магадлалыг хангах хэмжээнд түүвэрлэлтийн тоог тогтоон, тайлагнах
- Судалгааны үр дүнгийн тайланг тодорхой, асуудалд тулгуурлсан, ашиглах боломжтой арга хэлбэрээр бичих

АЙМАГ, НИЙСЛЭЛИЙН МЭНДИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН ХЭРЭГЛЭГЧДИЙН СЭТГЭЛ ХАНАМЖ

- Нотолгоонд тулгуурлан авсан арга хэмжээ, төлөвлөлт, үр дүнг тодорхой тайлагнах

Ховд аймаг: Тус аймаг нь судалгааны үр дүнгийн 3 хуудас мэдээлэл ирүүлсэн байна. Мэдээллээс харахад судалгаанд нийт 13 сумын 256 үйлчлүүлэгч, 146 эмч, эмнэлгийн мэргэжилтэн, ажилтан, нийт 402 хүн хамрагдсан байна. Үйлчлүүлэгчийн сэтгэл ханамжийн судалгааны ерөнхий сэтгэл ханамж 80.0%тай, эмч, эмнэлгийн мэргэжилтний ерөнхий сэтгэл ханамж 90.0% -тай байна.

Бусад эрүүл мэндийн байгууллагууд, тухайлбал, нэгдсэн эмнэлэг, өрхийн эрүүл мэндийн төвөөс судалгаа авсан мэдээлэл байхгүй байна. Үйлчлүүлэгчийн сэтгэл ханамжийн судалгаа нь амбулатори, хэвтэн эмчлүүлэх гэж ангилагдаагүй, нэг судалгаа байсан ба Амбулаторын судалгаанд хамааруулан авч үзсэн болно.

Судалгааны тайлан нь зөвхөн үзүүлэлт бүрийн дундаж оноог илэрхийлсэн ба 2015 онтой харьцуулахад 15.0%-иар өссөн гэсэн боловч, ямар үзүүлэлт өссөн нь харах боломжгүй байна. Судалгааны дүгнэлтэд цаашид судалгааг тогтмол авч хэвших, шийдвэр гаргалтад ашиглаж сурч байгаа талаар дурдсан боловч байна.

Дүгнэлт: Судалгааны үр дүнд тулгуурлан авсан арга хэмжээ тодорхой бус байна. Судалгааны түүврийг ямар эх олонлогоос хэрхэн хийсэн нь тодорхойгүй үнэн магадлалыг тогтоох боломжгүй байна.

Зөвлөмж:

- Судалгааны түүвэрлэлтийн хэмжээг, аргачлалд тулгуурлан үнэн, магадлалыг хангах хэмжээнд хүргэх
- Судалгааны үр дүнгийн тайланг тодорхой, асуудалд тулгуурлсан, ашиглах боломжтой арга хэлбэрээр бичих
- Нотолгоонд тулгуурлан авсан арга хэмжээ, төлөвлөлт, үр дүнг тодорхой тайлагнах

Хөвсгөл аймаг: Судалгааны нэгтгэлийг сайн, дунд, муу гэсэн үнэлгээгээр эксел файлаар ирүүлсэн байна. Судалгаанд бүх сум, өрхийн эрүүл мэндийн төв болон нийт 40 эрүүл мэндийн байгууллагаар үйлчлүүлсэн 11754 үйлчлүүлэгч, 758 эмч, эмнэлгийн мэргэжилтэн, ажилтан, нийт 12512 хүн хамрагдсан байна.

Үйлчлүүлэгчийн сэтгэл ханамжийн судалгааны ерөнхий сэтгэл ханамж 67.8%тай, эмч, эмнэлгийн мэргэжилтний ерөнхий сэтгэл ханамж 86.1% -тай байна. Судалгааны дүнгээс харахад бусад аймгаас харьцангуй олон үйлчлүүлэгч хамрагдсан сайн тал харагдаж байгаа боловч энэхүү судалгааны давтамжийг харах боломжгүй учир нэг удаагийн, эсвэл хэд хэдэн удаагийн судалгаа эсэхийг ялгах боломжгүй байна.

Мөн амбулатор, хэвтэн эмчлүүлэгч гэж ангилаагүй, нэгдсэн дүнгээр үзүүлэлт ирүүлсэн тул, амбулаторын сэтгэл ханамжийн судалгаанд хамааруулан авч үзлээ.

Судалгааны дүгнэлтэд судалгаанд хамрагдсан хүний тоо 1942-оор, сэтгэл ханамжийн хувь 1.2% иар нэмэгдсэн, үйлчлүүлэгчдээс эмнэлгийн мэргэжилтний хүрэлцээг нэмэгдүүлэх, ёс зүйг баримтлах, эм, эмнэлгийн хэрэгслийн хангамжийг нэмэгдүүлэхтэй холбоотой 12 санал ирсэнийг холбогдох байгууллагуудад уламжласнаа дурдсан байна. Мөн судалгааны нэгдсэн аргачлал, арга зүйн зөвлөгөө шаардлагатай байгаа гэсэн байна.

Дүгнэлт: Хөвсгөл аймгийн хэрэглэгчийн судалгаанд 40 байгууллагын 11754 үйлчлүүлэгч, 758 эмч, мэргэжилтэн, ажилтан хамрагдсан, олон хүнийг хамруулсан сайн талтай байна. Судалгаанаас гарсан саналыг байгууллагуудад хүргүүлсэн гэсэн ба авсан арга хэмжээ тодорхой бус байна. Судалгааны түүврийг ямар эх олонлогоос хийсэн, ямар давтамжтай хийсэн тодорхой бус байна.

Зөвлөмж:

- Судалгааны түүвэрлэлт, давтамжыг тодорхой тайлагнах
- Судалгааны мэдээлэлд дүн шинжилгээ хийж, үр дүнгийн тайланг “судалгааны тайлан” хэлбэрээр бичих
- Нотолгоонд тулгуурлан авсан арга хэмжээ, төлөвлөлт, үр дүнг тодорхой тайлагнах

АЙМАГ, НИЙСЛЭЛИЙН МЭНДИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН ХЭРЭГЛЭГЧДИЙН СЭТГЭЛ ХАНАМЖ

Хэнтий аймаг: Тус аймаг нь судалгааны 17 хуудас үр дүнгийн тайлан ирүүлсэн байна Судалгаанд сум, сум дунд, хөдөөгийн нэгдсэн эмнэлэг, өрхийн эрүүл мэндийн төв, аймгийн нэгдсэн эмнэлэг, уламжлалт анагаах ухааны төв, нийт 28 байгууллагаар үйлчлүүлсэн, 968 хэвтэн эмчлүүлэгч, 1681 амбулаторын үйлчлүүлэгч, 272 эмч, эмнэлгийн мэргэжилтэн, ажилтан нийт 2921 хүн хамрагдсан байна.

ЭМГ-ын хяналт үнэлгээний баг тайланд онд 3-4 удаа 21 сум, тосгоны эрүүл мэндийн төвд ажиллахдаа судалгаа авсан байна. Амбулаторын үйлчлүүлэгчийн ерөнхий сэтгэл ханамж 88.8%, хэвтэн эмчлүүлэгчдийн ерөнхий сэтгэл ханамж 88.7%, эмч, эмнэлгийн мэргэжилтний ерөнхий сэтгэл ханамж 88.1% -тай байна.

Судалгааг нэгдсэн аргачлалын дагуу, 3 бүлгээр буюу амбулатор, хэвтэн эмчлүүлэгч, эмч, эмнэлгийн мэргэжилтэн, ажилтаны сэтгэл ханамжийг тус бүр судалсан, үр дүнг 2014 онтой харьцуулан, дүгнэсэн, олон хүн хамрагдсан сайн тал харагдаж байна. Харьцуулалтаас харахад 2015 онд 2014 оноос өөрчлөлт бага байна.

Мөн тус аймаг нь судалгааны үр дүн, зөвлөмжийг нотолгоо болгон, цөөнгүй арга хэмжээ зохион байгуулнаа тайлагнасан байна.

Тухайлбал: Судалгааны дүгнэлтээс харахад судалгааны үр дүн, зөвлөмжид суурилан, сум, өрхийн эрүүл мэндийн төвийн хүний нөөцийн хангамж, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, эмнэлгийн халдвар хамгааллын дэглэм, эрүүл ахуй аюулгүй байдлыг сайжруулах, зөвлөх эмч, ижил мэргэжлийн эмч нарын үзлэгийн эрх зүйн орчныг шинэчлэх, тусламж, үйлчилгээний чанарыг сайжруулах сургалтууд зохион байгуулах, хүлээгдлийг бууруулах зохион байгуулалтын арга хэмжээ авах, албан бус сургалт, өдөрлөг зохион байгуулах, байгууллагын соёл, тохиожолтыг сайжруулах зэрэг арга хэмжээ авч, хэрэгжүүлсэнээ тайлагнасан байна.

Мөн эмч, эмнэлгийн мэргэжилтний сэтгэл ханамжийн судалгааны үр дүнд тулгуурлан эмч, ажилтаны эрүүл мэндийг хамгаалах, нийгмийн асуудлыг шийдвэрлэх, хувцаслалтыг жигдрүүлэх, шинэчлэх зэрэг арга хэмжээ авсан байна.

Дүгнэлт: Судалгааг хагас, бүтэн жилээр хийсэн гэсэн боловч, хооронд харьцуулан, ялгаж харах боломжгүй байна. Түүврийг ямар эх олонлогоос авсан, үнэн магадлалыг хэр хангасан нь тодорхой бус байна. Мөн судалгааны мөрөөр авсан арга хэмжээнд, хамааралгүй байх магадлалтай ажлуудыг тайлагнасан байдал анзаарагдав.

Зөвлөмж:

- Судалгааны түүвэрлэлт, давтамжыг тодорхой тайлагнах
- Судалгааны үр дүнгээр гарсан үзүүлэлт, санал, зөвлөмжийг төлөвлөлтийн хэлбэрт оруулан, төлөвлөлтийн дагуу хэрэгжүүлсэн ажлыг тодорхой тайлагнах

Увс аймаг: Тус аймаг нь судалгааны 14 хуудас бүхий тайлан ирүүлсэн байна. Тус аймаг нь аймгийн нэгдсэн эмнэлэг, Тариалан, Наранбулаг суманд аймгийн ЭМГ хяналт үнэлгээ хийх үедээ болон эрт илрүүлгийн үзлэг хийхдээ 8 удаа сэтгэл ханамжийн судалгаа авсанаа тайлагнасан байна.

Судалгаа нь:

- Нэгдсэн эмнэлгийн цаг товлох, эмнэлгийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмж, оношилгооны төвийн үйл ажиллагааны талаарх үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамж
- Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмж
- Эрт илрүүлэгч үзлэгийн үеэр авсан судалгаа тус тус хийгдсэн байна.

Энэхүү судалгаанууд нь нэгдсэн аргачлал, асуулгын дагуу хийгдээгүй, тус тусдаа зорилго, чиглэл агуулсан, тухайлбал: Цахим үйлчилгээний ажилтны ёс зүй, үйлчилгээний соёл, эмнэлгийн мэргэжилтний ёс зүй, үйлчилгээний соёл, нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмж зэрэг чиглэлээр авсан ба хамрагдсан цөөн тооны байгууллагыг нэгтгэж, нэгдсэн дүгнэлт гаргаагүй, сум бүрээр ирүүлсэн мэдээлэл байна.

Эрт илрүүлэгч арга хэмжээний үеэр 15 сумын 232 үйлчлүүлэгчээс эмнэлгийн мэргэжилтний ёс зүй, үйлчилгээний соёл, тэгш байдал, хүлээгдэл тусламж, үйлчилгээний соёл гэсэн 3 үзүүлэлтээр судалгаа авсан гэсэн боловч гаргасан үзүүлэлт ойлгомжгүй, шаардлага хангахгүй байна. Энэхүү судалгааны

АЙМАГ, НИЙСЛЭЛИЙН МЭНДИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН ХЭРЭГЛЭГЧДИЙН СЭТГЭЛ ХАНАМЖ

дүнгээс харахад эмнэлгийн мэргэжилтний ёс зүй, үйлчилгээний соёлын сэтгэл ханамжийн түвшин 69.0% тай, тусламж, үйлчилгээний чанарын үзүүлэлт 70.0% тай байна.

Судалгаанд суурилан, авсан арга хэмжээг товч тайлагнасан байна. Увс аймаг нь 2015 онд тушаалын дагуу нэгдсэн судалгаа хийгээгүй, өөр, өөр зорилтын хүрээнд сум, нэгдсэн эмнэлэгт цөөхөн хүн хамруулан, судалгаа хийсэн, нэгтгэж, дүгнэсэн тайлан ирүүлээгүй тул бусад аймагтай харьцуулахад тохиромжгүй байсан тул нэгдсэн хүснэгтэд оруулаагүй болно.

Дүгнэлт: Увс аймаг нь хэрэглэгчийн сэтгэл ханамжийн судалгааг нэгдсэн аргачлалын дагуу хийгээгүй, тус бүрдээ зорилго чиглэл агуулсан, бага хүрээнд, цөөн үйлчлүүлэгчдээс авсан байна. Судалгааны үр дүнгийн тайланд нэгдсэн дүгнэлт хийх боломжгүй байна.

Зөвлөмж:

- Судалгааны асуумжийг нэмэх, хасах нь нээлттэй боловч, ерөнхий суурь хэмжигдэхүүнийг хэвээр авч, нэгдсэн аргачлалд тулгуурлан хийх
- тайлангаа ойлгомж
- түүвэрлэлт, давтамжыг тодорхой тайлагнах
- Судалгааны үр дүнгээр гарсан үзүүлэлт, санал, зөвлөмжийг төлөвлөлтийн хэлбэрт оруулан, төлөвлөлтийн дагуу хэрэгжүүлсэн ажлыг тодорхой тайлагнах

2.2. НИЙСЛЭЛИЙН ХЭРЭГЛЭГЧИЙН СЭТГЭЛ ХАНАМЖИЙН СУДАЛГААНЫ ҮР ДҮН

Баянгол дүүргийн эрүүл мэндийн төв: Амбулаториор үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамжийн судалгаанд нийт 3024 хүн хамрагдсан байна. Стационарт хэвтэн эмчлүүлэгчийн болон эмнэлэгийн ажилчдын судалгааны мэдээлэл ирүүлээгүй болно.

Баянзүрх дүүргийн эрүүл мэндийн төв: Судалгаанд 3220 амбулаторын үйлчлүүлэгч, 220 эмч, эмнэлэгийн мэргэжилтэн, нийт 3440 хүн хамрагдсан байна. Судалгаагаар сэтгэл ханамж доогуур үнэлэгдсэн асуудлыг тодруулах зорилгоор амбулатори тус бүрээр үйлчлүүлж буй иргэдтэй фокус бүлгийн ярилцлага хийсэн байна.

Нийт 24 үйлчлүүлэгч хамрагдсан. Амбулатори бүрээр асуумж судалгаа, фокус бүлгийн ярилцлагын үр дүнг гаргасан ба тус бүрийн чанарын багуудтай нь хамтран судалгааны үр дүнд тулгуурласан богино хугацааны төлөвлөгөө гаргасан. Судалгааны үр дүн, зөвлөмжид суурилан төвийн эмч, ажилчдын нийгмийн хангамжийг сайжруулах, тусламж, үйлчилгээний чанарыг сайжруулах сургалтууд зохион байгуулах, байгууллагын соёл, тохижилтыг сайжруулах зэрэг арга хэмжээг дэлгэрэнгүй зураг, дүрслэлтэй тайлагнасан байна.

Багануур: Сэтгэл ханамжийн судалгаанд 300 амбулаторын үйлчлүүлэгч, 300 хэвтэн эмчлүүлэгч, 390 эмч, эмнэлэгийн мэргэжилтэн, хамрагдсан байна. Байгууллагын тусламж үйлчилгээг иргэдэд чирэгдэлгүй болгох, ард иргэдээс ирсэн санал гомдолд үндэсдэн байгууллагаас үзүүлж байгаа тусламж үйлчилгээнд өөрчлөлт оруулах, сайжруулах, ард иргэдэд эрүүл мэндийн боловсрол олгох сургалт, семинарыг зохион байгуулах гэх мэт ард иргэдэд чиглэсэн арга хэмжээ хэрэгжүүлсэн байна. Мөн 2015 онд гаднаас эм худалдан авсан 6 хүнд холбогдох баримтыг үндэслэн 719860 төгрөгийг буцаан олгосон талаар тусгасан байна.

Багахангай: Сэтгэл ханамжийн судалгааг Эрүүл мэндийн сайдын 2014 оны 13 тоот тушаалын дагуу боловсруулж ирүүлээгүй тул нэгтгэлд оруулах боломжгүй байсан.

Налайх: Сэтгэл ханамжийн судалгаанд 800 амбулаторын үйлчлүүлэгч, 2110 хэвтэн эмчлүүлэгчид хамрагдсан байна. Эмч, эмнэлэгийн ажилчдаас авсан судалгааны мэдээлэл байхгүй байна. Хэрэглэгчийн сэтгэл ханамжийг судлах, үнэлэлт дүгнэлт өгөх чиглэлээр НҮБ-ийн хүүхдийн сантай хамтарч хэрэгжүүлсэн ажлын талаар тусгасан байна.

Сүхбаатар дүүргийн эрүүл мэндийн төв: Судалгаанд 968 хэвтэн эмчлүүлэгч, 2458 амбулаторын үйлчлүүлэгч, 210 эмч, эмнэлгийн мэргэжилтэн, ажилтан нийт 2668 хүн хамрагдсан байна. Хэвтэн эмчлүүлэгч нарын мэдээлэл ирүүлээгүй болно.

Сонгино-Хайрхан дүүргийн эрүүл мэндийн төв: Сэтгэл ханамжийн судалгааг Эрүүл мэндийн сайдын 2014 оны 13 тоот тушаалын дагуу боловсруулж ирүүлээгүй тул нэгтгэлд оруулах боломжгүй байсан.

Сонгино-Хайрхан дүүргийн нэгдсэн эмнэлэг: Сэтгэл ханамжийн судалгааг Эрүүл мэндийн сайдын 2014 оны 13 тоот тушаалын дагуу боловсруулж ирүүлээгүй тул нэгтгэлд оруулах боломжгүй байсан.

Чингэлтэй дүүргийн эрүүл мэндийн төв: Судалгаанд төв салбар, хайлааст салбар, бага тойруу салбар, нэгдсэн эмнэлгийн амбулаторийн үйлчлүүлэгч-400, хэвтэн эмчлүүлэгч-400, эмч, эмнэлгийн ажилчид-352 хамрагдсан. Судалгааны тайланд сэтгэл ханамжийн түвшинг тодорхой бичээгүй, 70%-аас доош сэтгэл ханамжтай үзүүлэлтийн дагуу авч хэрэгжүүлсэн үйл ажиллагааны тайлан хэлбэрээр бичсэн байгаа тул сэтгэл ханамжийн түвшинг харах боломжгүй байна.

Үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамж 70% аас доогуур байгаа асуудлуудын хүрээнд эмнэлгийн орчныг тохижуулах, тусламж, үйлчилгээний чиглэлээр тайлбар, мэдээлэл өгөх, эрүүл ахуй, халдвар хамгаалал болон хүлэгдэл, чирэгдлийг бууруулах зэрэг 11 чиглэлийн 27 үйл ажиллагаа авч хэрэгжүүлсэн. Мөн эмч, эмнэлгийн ажилчдын сэтгэл ханамж 70%-аас доогуур байгаа асуудлын мөрөөр 9 чиглэлийн 13 үйл ажиллагаа авч хэрэгжүүлсэн.

Өргөө амаржих газар:

Судалгаанд

- эх барих стационарын жирэмсний эмгэгийг эмчлэх хэсэгт хэвтэн эмчлүүлсэн, хүлээн авах яаралтай тусламжийн хэсгээр үйлчлүүлсэн эхээс, амаржсан нийт 13492 эхийн 782 (5.7%)-аас нь,
- эмэгтэйчүүдийн стационараар үйлчлүүлсэн нийт 3016 үйлчлүүлэгчийн 225 (7.5%)-оос нь,
- амбулаторийн хэсгээр үйлчлүүлсэн нийт 34449 үйлчлүүлэгчийн 1475 (4.3%)-аас нь сэтгэл ханамжийн судалгаа авсан байна.
- Нийт 468 эмч, 455 эмнэлгийн ажилчид (97.2%)-г хамруулсан.

Судалгааны тайланг ЭМСайдын 2014.01.13-ны өдрийн тушаалаар баталсан асуумжийн дагуу бүлэг тус бүрээр бичээгүй тул бүлэг тус бүрд харгалзах сэтгэл ханамжийн түвшинг тавих боломжгүй, зөвхөн ерөнхий сэтгэл ханамжийн түвшинг харах боломжтой байна. Мөн эмч, эмнэлгийн ажилчдын сэтгэл ханамжийн судалгааны үр дүнг тайлагнахдаа сэтгэл ханамж хамгийн доогуур байгаа үзүүлэлтийг авч бичсэн тул ерөнхий сэтгэл ханамжийн түвшинг харах боломжгүй байна. Үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамж дундуур байгаа асуудлын хүрээнд тусламж үйлчилгээний ачаалал, хүлээгдлийг бууруулах, эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийг чадвхижуулах болон ёс зүйн сургалтууд, эрүүл ахуй, халдвар хамгааллыг сайжруулах зэрэг 8 чиглэлийн үйл ажиллагааг хэрэгжүүлсэн байна.

Амгалан амаржих газар: Сэтгэл ханамжийн судалгаанд 4 тасгийн 1486 үйлчлүүлэгч буюу хэвтэн эмчлүүлэгчийн 28.4% нь судалгаанд хамрагдсан байна. Судалгааны асуумж нь ЭМСайдын 2014.01.13-ны өдрийн тушаалаар баталсан асуумжаас өөр байгаа тул ерөнхий сэтгэл ханамжийн түвшинг авлаа.

Эмч, эмнэлгийн ажилчдын сэтгэл ханамжийн судалгааны мөрөөр хөдөлмөр хамгаалал, аюулгүй аиллагаа, төрийн болон салбарын шагнал, цалин, нэмэгдэл, урамшуулал, тэтгэмж, тэгэлэг, буцалтгүй тусламж зэрэг 7 чиглэлийн 30 гаруй үйл ажиллагаануудыг дурдсан боловч эдгээр үйл ажиллагаа нь судалгааны мөрөөр авч хэрэгжүүлсэн үйл ажиллагаа бус тухайн байгууллагын тогтмол хийгддэг үндсэн үйл ажиллагаа байна.

Нийслэлийн яаралтай тусламжийн төв: Нийслэлийн яаралтай тусламжийн төв нь үйлчлүүлэгчдээс улирал бүр, эмч, эмнэлгийн ажилчдаас 1 ба 3 дугаар улиралд тус тус сэтгэл ханамжийн судалгаа авсан байна. Судалгаанд жилийн эцсийн байдлаар нийт 450 гаруй үйлчлүүлэгч, 128 эмч, эмнэлгийн ажилчид хамрагдсан байна.

Шүд, эрүү нүүрний төв: Шүд, эрүү нүүрний төв нь үйлчлүүлэгчдээс улирал бүр сэтгэл ханамжийн судалгаа авсан байна. Харин эмч, эмнэлгийн ажилчдаас судалгаа аваагүй байна. Жилийн эцсийн байдлаар нийт 1162 үйлчлүүлэгч судалгаанд хамрагдсан байна.

Судалгааны асуумжийн хувьд 1-р улирлын асуумж нь ЭМСайдын 2014.01.13-ны өдрийн тушаалаар баталсан асуумжийн дагуу, харин бусад 3 улирал нь хураангуй асуумжаар судалгааг авчээ. Тиймээс бүлэг тус бүрээр сэтгэл ханамжийн дүнг гаргах боломжгүй, ерөнхий сэтгэл ханамжийн дүнгэр мэдээллийг авлаа.

Хонхор тосгоны эмнэлэг: Судалгааг 2 удаа авсан ба амбулаторийн үйлчлүүлэгчдийн 72.8% (584 үйлчлүүлэгч), хэвтэн эмчлүүлэгчдийн 27.1% (218 үйлчлүүлэгч), эмч, эмнэлгийн ажилчид 100% (22 хүн)

АЙМАГ, НИЙСЛЭЛИЙН МЭНДИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН ХЭРЭГЛЭГЧДИЙН СЭТГЭЛ ХАНАМЖ

тус тус хамрагдсан байна. Судалгааны тайланд сэтгэл ханамжийн түвшинг тодорхой дурдаагүй, сэтгэл ханамжийн түвшин 70-аасдоош хувьтай асуудлын мөрөөр авч хэрэгжүүлсэн үйл ажиллагааг тайлагнасан байгаа тул ерөнхий сэтгэл ханамжийн түвшинг тодорхойлох боломжгүй байна.

Үйлчлүүлэгчийн сэтгэл ханамжийн мөрөөр эмч, эмнэлгийн ажилчдын цаг ашиглалтыг сайжруулах, харилцааны ёс зүйг дээшлүүлэх, эмнэлгийн орчин нөхцөл сайжруулах 3 чиглэлийн үйл ажиллагаа авч хэрэгжүүлсэн байна. Харин эмч, эмнэлгийн ажилчид авч буй цалин, урамшуулалд сэтгэл ханамжгүй байгаа ба ажилчдын ажлыг сар бүр дүгнэж хангалттай үнэлгээ авсан ажилчдад улирал бүр цалингийн 30-45%-иар урамшуулал олгож байна. Улиралд дунджаар 12-15 ажилтан үр дүнгийн урамшуулалд хамрагдаж байна.

Гачуурт тосгоны эмнэлэг: Судалгаанд эмнэлэгт хэвтэн эмчлүүлэгч болон шүдний кабинетаар үйлчлүүлсэн 400 үйлчлүүлэгч, 17 эмч, эмнэлгийн ажилчдыг хамруулсан байна. Үйлчлүүлэгчийн судалгааг амбулатори, стационараар үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамж гэж ялгаж гаргаагүй байгаа тул үйлчлүүлэгчийн сэтгэл ханамжийн дүнг стационарын сэтгэл ханамж гэж авч үзлээ. Судалгааны мөрөөр орчны тохижилтыг сайжруулах, оношилгоо, эмнэлгийн багаж тоног төхөөрөмжийн хүрэлцээг нэмэгдүүлэх, ажлын байрны чийрэгжилт, алжаал тайлах нөхцөлийг сайжруулах чиглэлээр үйл ажиллагаа хэрэгжүүлсэн байна.

Дүгнэлт:

- Судалгаанд 9 дүүргийн эрүүл мэндийн төв, 1 дүүргийн нэгдсэн эмнэлэг, 2 амаржих газар, 2 тосгоны эмнэлэг, Нийслэлийн яаралтай тусламжийн төв, Шүд, эрүү нүүрний төв, нийт 16 байгууллага хамрагдсан байна. НЭМГ-ын харьяа байгууллагуудын хийсэн хэрэглэгчийн сэтгэл ханамжийн судалгаанаас боломжит бүх үр дүнгүүдийг авч нэгтгэн үзэхэд амбулаториор үйлчлүүлэгчийн сэтгэл ханамж 77.05%, стационараар үйлчлүүлэгчийн сэтгэл ханамж 79.25%, эмч, эмнэлгийн ажилчдын сэтгэл ханамж 64.7% байна.
- Судалгаанд дүүргийн эрүүл мэндийн төв, нэгдсэн эмнэлгээс гадна бусад байгууллагууд (амаржих газар, тосгоны эмнэлэг гэх мэт)-ыг хамруулсан нь урьд жилүүдийн судалгааны хамрах хүрээнээс давуу талтай байна. Мөн зарим байгууллагууд сэтгэл ханамжийн судалгааны мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаар тайлагнасан сайн тал харагдлаа.
- Эрүүл мэндийн байгууллагуудын судалгааны давтамж нь байгууллага бүрд харилцан адилгүй, ЭМСайдын тушаалд заасан хамрагдах шаардлагатай субъектууд (амбулаториор үйлчлүүлэгч, стационараар үйлчлүүлэгч, эмч, эмнэлгийн ажилчид)-ыг бүрэн хамруулаагүй дутагдалтай тал харагдаж байна.
- Нийтлэгээр судалгааны тайлангийн боловсруулалт хангалтгүй. Тухайн байгууллагын үйл ажиллагаанд үйлчлүүлэгч болон эмч, эмнэлгийн ажилчдын сэтгэл ханамжийн түвшин ямар байгаа нь тодорхойгүй. Сэтгэл ханамжийн түвшин зөвхөн 70-аас доош хувьтай асуудлыг тодотгож бичсэн зэрэг цаашид анхаарах шаардлагатай асуудлууд байна.
- НЭМГ-ын харьяа байгууллагуудын хэрэглэгчийн сэтгэл ханамжийн судалгааны нэгдсэн тайлан байхгүй байна.

Зөвлөмж:

- Хэрэглэгчийн сэтгэл ханамжийн судалгааны зохион байгуулалтын хувьд ЭМСайдын 2014 оны 13 дугаар тушаалын хэрэгжилтийг хангаж ажиллах.
- Байгууллагуудын хэрэглэгчийн сэтгэл ханамжийн судалгааны тайлан боловсруулах үр чадварыг сайжруулах
- НЭМГ-ын харьяа байгууллагуудын хэрэглэгчийн сэтгэл ханамжийн нэгдсэн тайлан боловсруулдаг байх.

2.3. СУДАЛГААНЫ ЕРӨНХИЙ ҮР ДҮН

2.3.1. Хэвтэн эмчлүүлэгчдийн сэтгэл ханамжийн судалгааны ерөнхий үр дүн:

21 аймаг, НЭМГ-ын хэвтэн эмчлүүлэгчдийн сэтгэл ханамжийн судалгааны нийлбэр дунджаар байгууллагын соёл 83.1 %, эмнэлгийн мэргэжилтний ёс зүй, үйлчилгээний соёл 82.9 %, тусламж үйлчилгээний чанар, аюулгүй байдал 83.8%, удирдлага зохион байгуулалт 81.8%, ерөнхий сэтгэл

АЙМАГ, НИЙСЛЭЛИЙН МЭНДИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН ХЭРЭГЛЭГЧДИЙН СЭТГЭЛ ХАНАМЖ

ханамж 80.6 % -тай байна (Хэвтэн эмчлүүлэгчдийн сэтгэл ханамжийн түвшингийн дэлгэрэнгүйг хавсралт 1-ээс харна уу).

Хэвтэн эмчлүүлэгчдийн сэтгэл ханамжийн байдлыг эрүүл мэндийн байгууллагаар нь харьцуулан авч үзвэл байгууллагын соёлд Говь-Алтай аймаг хамгийн өндөр 96.1 %, дараа нь Булган аймаг 92.1%, Баянхонгор аймаг 89% байхад НЭМГ хамгийн бага 74.6% -ийн үнэлгээтэй байна.

Эмнэлгийн мэргэжилтний ёс зүй, үйлчилгээний соёлд хэвтэн эмчлүүлэгчдийн өгсөн сэтгэл ханамжийн үнэлгээ Говь-Алтай аймагт хамгийн өндөр 97.6 %, Булган аймаг 91.9%, Хэнтий аймаг 89.1%, харин хамгийн бага үнэлгээг Архангай аймаг-66.2% авсан бол НЭМГ 80.6%-тай байна.

Тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдалд хэвтэн эмчлүүлэгчдийн өгсөн сэтгэл ханамжийн үнэлгээ мөн Говь-Алтай аймагт хамгийн өндөр 94.2%, Архангай аймагт хамгийн бага 76,8%, харин НЭМГ-т 73.6% байна. Удирдлага зохион байгуулалтын байдалд Говь-Алтай аймагт хамгийн өндөр 95.8%, хамгийн бага 68%-ийн үнэлгээг Завхан аймаг авсан бол НЭМГ 65.7%-ийн үнэлгээтэй байна. Хэвтэн эмчлүүлэгчдийн ерөнхий сэтгэл ханамжийн байдал Говь-Алтай аймагт хамгийн өндөр 95.9 %, Булган аймаг 89.1%, Хэнтий аймаг 88.7%, харин Сүхбаатар аймаг хамгийн бага 69%, НЭМГ-т 79.3% байна.

2.3.2. Амбулаторын үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамжийн судалгааны ерөнхий үр дүн:

Аймаг, НЭМГ-ын амбулаториор үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамжийн судалгааны нийлбэр дунджаар байгууллагын соёл 79.0 %, эмнэлгийн мэргэжилтний ёс зүй, үйлчилгээний соёл 81.0 %, тусламж үйлчилгээний чанар, аюулгүй байдал 80.4%, удирдлага зохион байгуулалт 79.3%, ерөнхий сэтгэл ханамж 79.0 % -тай байна. (Амбулаторын үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамжийн түвшингийн дэлгэрэнгүйг хавсралт 2-оос харна уу).

Амбулаториор үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамжийг эрүүл мэндийн байгууллагаар нь харьцуулан авч үзвэл байгууллагын соёлд Говь-Алтай аймаг хамгийн өндөр 90.5 %, дараа нь Дундговь аймаг 90.3%, Хөвсгөл аймаг 87.8% байхад НЭМГ хамгийн бага 68.5% -ийн үнэлгээтэй байна.

Эмнэлгийн мэргэжилтний ёс зүй, үйлчилгээний соёлд хэвтэн эмчлүүлэгчдийн өгсөн сэтгэл ханамжийн үнэлгээ Говь-Алтай аймагт хамгийн өндөр 96.0 %, Хэнтийн аймаг 89.6%, Хөвсгөл аймаг 88.9%, харин хамгийн бага үнэлгээг Баянхонгор аймаг-66.6% авсан бол НЭМГ 74.4%-тай байна.

Тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдалд хэвтэн эмчлүүлэгчдийн өгсөн сэтгэл ханамжийн үнэлгээ мөн Говь-Алтай аймагт хамгийн өндөр 96.2%, Архангай аймагт хамгийн бага 74.3%, харин НЭМГ-т 70.0% байна. Удирдлага зохион байгуулалтын байдалд Говь-Алтай аймагт хамгийн өндөр 94.7%, хамгийн бага 56%-ийн үнэлгээг Завхан аймаг авсан бол НЭМГ 65.4%-ийн үнэлгээтэй байна.

Амбулаториор үйлчлүүлэгчдийн ерөнхий сэтгэл ханамжийн байдал Говь-Алтай аймагт хамгийн өндөр 94.4 %, Хөвсгөл аймаг 92.8%, Хэнтий аймаг 88.8%, харин Орхон аймаг хамгийн бага 62.1%, НЭМГ-т 77.1% байна.

2.3.3. Эмч, эмнэлгийн мэргэжилтэн, ажилчдын сэтгэл ханамжийн судалгааны ерөнхий үр дүн:

Аймаг, НЭМГ-ын эмч, эмнэлгийн мэргэжилтний сэтгэл ханамжийн түвшний судалгааны нийлбэр дунджаар байгууллагаас үзүүлдэг дэмжлэг удирдлагад 74.8 %, хүний нөөцийн хөгжих боломжид 74.8 %, эмнэлгийн мэргэжилтний ёс зүй, үйлчилгээний соёлд 81.6%, байгууллагын соёлд 83.0% тусламж үйлчилгээний чанар, аюулгүй байдал 79.5%, ажлын байрны аюулгүй дэмжлэгт орчинд 75.6%-ийн үнэлгээ гарсан бөгөөд ерөнхий сэтгэл ханамжийн түвшин 76.9 % -тай байна (Эмч, эмнэлгийн мэргэжилтэн, ажилтаны сэтгэл ханамжийн түвшингийн дэлгэрэнгүйг хавсралт 3-аас харна уу).

Эмч, эмнэлгийн мэргэжилтний сэтгэл ханамжийг эрүүл мэндийн байгууллагаар нь харьцуулан авч үзвэл дэмжлэг удирдлагад Говь-Алтай аймаг хамгийн өндөр 94.6%, дараа нь Өмнөговь аймаг 91.0%, Хөвсгөл аймаг 83.8% байхад НЭМГ хамгийн бага 53.4% -ийн үнэлгээтэй байна.

АЙМАГ, НИЙСЛЭЛИЙН МЭНДИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН ХЭРЭГЛЭГЧДИЙН СЭТГЭЛ ХАНАМЖ

Хүний нөөцийн хөгжих боломжоор Хэнтий аймаг 94.7%-иар хамгийн өндөрт, дараа нь Ховд аймаг 90.0%, Говь-Алтай 89.1%, хамгийн багаар Баянхонгор аймаг 54.5%, харин НЭМГ 55.1%-тай байна. Эмнэлгийн мэргэжилтний ёс зүй, үйлчилгээний соёлд Говь-Алтай аймаг 91.5%, дараа нь Хөвсгөл аймаг 88.1%, Ховд аймаг 88.0%, хамгийн бага нь НЭМГ 64.6%-тай байна.

Байгууллагын соёл үзүүлэлтэнд хамгийн өндөр нь Говь-Алтай аймаг 98.0%, дараа нь Баянхонгор аймаг 96.0%, Хэнтий аймаг 89.9%, хамгийн багаар Завхан аймаг 56.0%, харин НЭМГ 58.3% гэсэн үнэлгээ авсан байна.

Тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдалд хамгийн өндөрөөр Говь-Алтай 95.2%, Хөвсгөл аймаг 89.9%, Хэнтий аймаг 89.5%, хамгийн бага нь Завхан аймаг 50.0%, харин НЭМГ 58.8%-тай байна. Ажлын байрны аюулгүй, дэмжлэгт орчинд хамгийн өндөрөөр Ховд аймаг 90.0%, дараа нь Өмнөговь аймаг 89.0%, Говь-Алтай аймаг 88.7%, хамгийн бага нь НЭМГ 45.6% байна.

Эмч, эмнэлгийн мэргэжилтний ерөнхий сэтгэл ханамжаар хамгийн өндөрт Говь-Алтай аймаг 92.9%, Ховд аймаг 90.0%, Өмнөговь аймаг 87.7% байхад хамгийн бага нь Сүхбаатар аймаг 47.2%-тай, харин НЭМГ 54.8% гэсэн үнэлгээ авсан байна.

2.3.4. Тэгш байдал, ашиг сонирхолын байдал: Судалгааны энэхүү асуулга нь үйлчлүүлэгчид нь эмч, эмнэлгийн мэргэжилтнээс чанартай, хүлээгдэлгүй, шуурхай тусламж, үйлчилгээ авахын тулд шан харамж, албан бус төлбөр төлдөг байдлыг тандах, нөгөө талаас эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг тэгш хүртэх боломжийг судлах зорилгоор 6 хувьсах хэмжигдэхүүн бүхий асуулгаас бүрдсэн бүлэг юм. Энэ бүлгийн асуулга нь судалгааны бусад бүлгүүдийн асуулга шиг сайн, дунд, муу гэсэн үнэлгээ өгөх хэлбэрээр биш, тийм, үгүй, мэдэхгүй гэсэн хариултаар хийгдсэн болно. Иймд бид нэгтгэлдээ энэхүү бүлгийг тусгайд нь авч үзлээ. Гэхдээ энэ хэсэгт эрүүл мэндийн байгууллагуудын дийлэнх хэсэг нь шаардлага хангаагүй, дутуу мэдээлэл ирүүлсэн учраас нэгдсэн дүгнэлт, зөвлөмж гаргах боломжгүй байна.

Аймгуудаас 6 аймаг буюу Архангай, Дархан-Уул, Дорноговь, Сэлэнгэ, Увс, Хөвсгөл аймаг, нийслэлээс Баянгол дүүргийн эрүүл мэндийн төв, Шүд, эрүү нүүрний төв, 2 байгууллага, нийт 8 байгууллагын ирүүлсэн мэдээлэл нь шаардлага хангаж байна.

Мэдээллээ аргачлалын дагуу ирүүлсэн энэхүү 8 эрүүл мэндийн байгууллагын асуумжаас харахад судалгаанд оролцогчдын 22.4% нь тусламж, үйлчилгээ авах, хүлээгдлийг багасгах, үйлчилгээг шуурхай болгохын тулд шан харамж, албан бус төлбөр өгдөг, 35.1% нь гаднаас эм тариа авчруулдаг, 22.0% нь эмнэлэгт таних хүнгүй бол тусламж, үйлчилгээ авахад бэрхшээлтэй, 11.0% нь эмч, эмнэлгийн мэргэжилтэн хувийн эмнэлэг, эмийн сан, сүлжээ санал болгодог, хувиасаа эм зардаг, 27.2 нь эрүүл мэндийн даатгалгүй тохиолдолд тусламж, үйлчилгээ чирэгдэлгүй авах боломжгүй, 22.7 нь үйлчлүүлэгч эмчээ сонгож үйлчлүүлэх боломжгүй гэж үзсэн байна.

2.3.5. Судалгаанд хамрагдсан нийт оролцогчдын сэтгэл ханамжийн ерөнхий түвшин:

21 аймаг, НЭМГ-ын хэвтэн эмчлүүлэх, амбулаториор үйлчлүүлэгч, эмч, эмнэлгийн мэргэжилтний гэсэн 3 бүлгийн сэтгэл ханамжийн ерөнхий түвшинг нэгтгэн авч үзвэл хамгийн өндөр гарсан нь Говь-Алтай аймаг 94.4%, дараа нь Хөвсгөл аймаг 89.45%, Хэнтий аймаг 88.2% гарсан байхад хамгийн бага нь Сүхбаатар аймаг 59.8%, харин НЭМГ нь нийтдээ 72.8% гэсэн үнэлгээ авсан байна.

Ерөнхий сэтгэл ханамжийн дүнг нэгтгэвэл нийлбэр дунджаар 21 аймаг болон НЭМГ 79.9%-тай, судалгаанд нийтдээ 80309 хүн (тухайн аймаг болон НЭМГ-уудын тайлан дээрээс боломжит бүх тоог авч дүгнэсэн болно) хамрагдсан байна. Судалгаанд 21 аймгийн эрүүл мэндийн байгууллагуудын амбулаториор үйлчлүүлэгч, хэвтэн эмчлүүлэгч, эмч, эмнэлгийн мэргэжилтний нийт 50743 хүн хамрагдсан байна. Байгууллагуудаас ирсэн тайлангаас боломжит бүх үр дүнгүүдийг авч нэгтгэн үзэхэд амбулаториор үйлчлүүлэгчийн сэтгэл ханамж 78.4%, стационараар үйлчлүүлэгчийн сэтгэл ханамж 82.2%, эмч, эмнэлгийн ажилчдын сэтгэл ханамж 76.9% байна.

ДҮГНЭЛТ

21 аймгийн Эрүүл мэндийн газар, нийслэлийн 9 дүүргийн 16 эрүүл мэндийн байгууллагын хэрэглэгчдийн сэтгэл ханамжийн судалгааны тайланг нэгтгэн дүгнэлээ.

АЙМАГ, НИЙСЛЭЛИЙН МЭНДИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН ХЭРЭГЛЭГЧДИЙН СЭТГЭЛ ХАНАМЖ

Судалгаанд 21 аймгийн эмч, эмнэлгийн мэргэжилтэн, эрүүл мэндийн байгууллагуудын амбулаториор үйлчлүүлэгч, хэвтэн эмчлүүлэгч 50743, нийслэлийн эрүүл мэндийн байгууллагуудын амбулаториор үйлчлүүлэгч, хэвтэн эмчлүүлэгч 29566, нийт 80390 хүн хамрагдсан байна.

Байгууллагуудаас ирсэн тайлангаас боломжит бүх үр дүнгүүдийг авч нэгтгэн дүгнэхэд амбулаторын нийт үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамжийн түвшин 78.4%, хэвтэн эмчлүүлэгчдийн сэтгэл ханамжын түвшин 82.2%, эмч, эмнэлгийн ажилчдын сэтгэл ханамжын түвшин 76.9% байна.

Хэвтэн эмчлүүлэгчдийн сэтгэл ханамжийн түвшин, дунджаар байгууллагын соёл 83.1 %, эмнэлгийн мэргэжилтний ёс зүй, үйлчилгээний соёл 82.9 %, тусламж үйлчилгээний чанар, аюулгүй байдал 83.8%, удирдлага зохион байгуулалт 81.8%, ерөнхий сэтгэл ханамж 80.6 % -тай байна.

Хэвтэн эмчлүүлэгчдийн ерөнхий сэтгэл ханамжийн түвшингээр Говь-Алтай аймаг хамгийн өндөр 95.9 %, Булган аймаг 89.1%, Хэнтий аймаг 88.7%, харин Сүхбаатар аймаг хамгийн бага 69%, НЭМГ-т 79.3% байна.

Амбулаториор үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамжийн түвшин, дунджаар байгууллагын соёл 79.0 %, эмнэлгийн мэргэжилтний ёс зүй, үйлчилгээний соёл 81.0 %, тусламж үйлчилгээний чанар, аюулгүй байдал 80.4%, удирдлага зохион байгуулалт 79.3%, ерөнхий сэтгэл ханамж 79.0 % -тай байна.

Амбулаториор үйлчлүүлэгчдийн ерөнхий сэтгэл ханамжийн түвшингээр Говь-Алтай аймагт хамгийн өндөр 94.4 %, Хөвсгөл аймаг 92.8%, Хэнтий аймаг 88.8%, харин Орхон аймаг хамгийн бага 62.1%, НЭМГ-т 77.1% байна.

Эмч, эмнэлгийн мэргэжилтний сэтгэл ханамжийн түвшин, дунджаар байгууллагаас үзүүлдэг дэмжлэг удирдлагад 74.8 %, хүний нөөцийн хөгжих боломжид 74.8 %, эмнэлгийн мэргэжилтний ёс зүй, үйлчилгээний соёлд 81.6%, байгууллагын соёлд 83.0% тусламж үйлчилгээний чанар, аюулгүй байдал 79.5%, ажлын байрны аюулгүй дэмжлэгт орчинд 75.6%-ийн үнэлгээ гарсан бөгөөд ерөнхий сэтгэл ханамжийн түвшин 76.9 % -тай байна.

Эмч, эмнэлгийн мэргэжилтний ерөнхий сэтгэл ханамжийн түвшингээр хамгийн өндөрт Говь-Алтай аймаг 92.9%, Ховд аймаг 90.0%, Өмнөговь аймаг 87.7% байхад хамгийн бага нь Сүхбаатар аймаг 47.2%-тай, харин НЭМГ 54.8% гэсэн үнэлгээ авсан байна.

Сэтгэл ханамжийн ерөнхий түвшинг нэгтгэн авч үзвэл хамгийн өндөр гарсан нь Говь-Алтай аймаг 94.4%, дараа нь Хөвсгөл аймаг 89.45%, Хэнтий аймаг 88.2% гарсан байхад хамгийн бага нь Сүхбаатар аймаг 59.8%, харин НЭМГ нь нийтдээ 72.8% гэсэн үнэлгээ авсан байна.

Судалгаанд хамрагдсан 80309 хүний ерөнхий сэтгэл ханамжийн дүнг нэгтгэн үзэл, нийлбэр дунджаар 79.9%-тай байна.

Эрүүл мэндийн байгууллагууд нь судалгааны мэдээллийг цуглуулахдаа ЭМСайдын 2014 оны 13 дугаар тушаалын хавсралтаар баталсан нэгдсэн асуумжийн дагуу жигд аваагүй, мэдээлэлд боловсруулалт хийхдээ нэгдсэн аргачлалыг баримтлаагүй байна.

Судалгааны түүврийг ямар эх олонлогоос хэрхэн хийсэн нь тодорхойгүй, үнэн магадлалтай эсэхийг тогтоох боломжгүй байна.

Хэрэглэгчийн сэтгэл ханамжийн судалгааны давтамж нь байгууллага бүрд харилцан адилгүй, тушаалаар заасан хамрагдах шаардлагатай субъектуудыг бүрэн хамруулаагүй, эсвэл ялгах боломжгүй байдлаар үр дүнг тайлагнасан, сэтгэл ханамжийн түвшинг тус бүрээр тодорхойлоход хүндрэлтэй байна.

Судалгааны үр дүнг тодорхой тайлагнаагүй, судалгааны үр дүнд тулгуурлан авсан арга хэмжээг зарим байгууллагууд тайлагнасан байхад зарим нь огт тайлагнаагүй, зарим байгууллагууд эксел файлаар, дүгнэлтгүй, зөвхөн нэгтгэл ирүүлсэн, зарим нь маш товч байдлаар ерөнхий түвшинг ирүүлсэн зэрэг нэгдсэн дүгнэлт хийхэд бэрхшээл учруулсан асуудлууд цөөнгүй байна.

Судалгаанаас гарсан санал, зөвлөмжид тулгуурлан авсан арга хэмжээ, үйл ажиллагааны тайланг харахад, судалгааны үр дүнд хамааралгүй, бусад чиглэлээр хийсэн үйл ажиллагааг тайлагнасан байх гэсэн таамаглал төрүүлэв.

Аймаг, нийслэлийн эрүүл мэндийн байгууллагууд нь сэтгэл ханамжийн судалгааны асуумж нь хэт олон, зарим асуулга ойлгомж муутай, мөн судалгааны хийх мэргэжил арга зүй дутагдаж байгаа талаар санал ирүүлсэн байна.

ЗӨВЛӨМЖ

Хэрэглэгчийн сэтгэл ханамжийн судалгааны үр дүн нь байгууллагын үйл ажиллагааны гүйцэтгэлийн чанар, үр дүнгийн түвшинг харуулж чадахуйц ач холбогдолтой байлгах зорилгоор зарчмын хэд хэдэн алхмыг хийх шаардлагатай байна.

Үүнд:

- Орц буюу ЭМСайдын 2014 оны 13 дугаар тушаалаар батлагдсан аргачлалаар, үнэн магадлалыг хангасан түүвэрлэлтийн дагуу судалгааг хийх
- Явц буюу судалгааны мэдээлэл цуглуулахаас эхлээд, мэдээллийг аргачлалын дагуу боловсруулах, дүн шинжилгээ хийх, судалгааны үр дүнгийн тайлан бичих үйл явцыг нэгдсэн нэг загвараар боловсруулахад мэргэжил арга зүйгээр хангах
- Гарц буюу сэтгэл ханамжийн судалгааны үр дүнгийн эцсийн бүтээгдэхүүн нь бодлого боловсруулагч, шийдвэр гаргагчид болон үйлчлүүлэгчид ойлгомжтой, нэгдсэн байдлаар гарч, байгууллагуудыг харьцуулан үнэлэх боломжтой байх шаардлагатайг байгууллагуудын удирдлагын түвшинд анхааралдаа авч, судалгаа хариуцсан хүний нөөцийг сургаж бэлтгэх
- Судалгааний үр дүн, ач холбогдол нь нотолгоонд суурилсан төлөвлөгөө хийх, хэрэгжилтийг хангах, тулгамдсан асуудлыг шийдвэрлэхийг зорьж байгаа тул, судалгаанаас гарсан санал, зөвлөмжид тулгуурлан авсан арга хэмжээ, үйл ажиллагааг, судалгааны үр дүнгийн тайлантай хамт ирүүлж байх

ХАВСРАЛТ 1. ХЭВТЭН ЭМЧЛҮҮЛЭГЧДИЙН СЭТГЭЛ ХАНАМЖИЙН ТҮВШИН (АЙМАГ, НИЙСЛЭЛ)

	Аймаг	Үзүүлэлт					Ерөнхий сэтгэл ханамж
		Байгууллагын соёл	Эмнэлгийн мэргэжилтний ёс зүй, үйлчилгээний соёл	Тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдал	Удирдлага, зохион байгуулалт		
1	Архангай	75.9	66.2	76.8	84.9	75.3	
2	Баян-Өлгий	-	-	-	-	-	
3	Баянхонгор	89.0	82.0	82.0	89.0	83.5	
4	Булган	92.1	91.9	89.5	82.8	89.1	
5	Говь Алтай	96.1	97.6	94.2	95.8	95.9	
6	Говьсүмбэр	-	-	-	-	78.8	
7	Дархан	78.6	73.4	80.4	80.9	81.6	
8	Дорноговь	-	-	-	-	-	
9	Дорнод	-	-	-	-	-	
10	Дундговь	-	-	-	-	-	
11	Завхан	75.0	75.0	81.0	68.0	74.7	
12	Орхон	-	-	-	-	80.0	
13	Өвөрхангай	-	-	-	-	80.2	
14	Өмнөговь	86.0	85.8	87.3	78.2	84.3	
15	Сүхбаатар	-	-	-	-	69.0	
16	Сэлэнгэ	-	-	-	-	-	
17	Төв	84.2	87.7	84.0	80.5	78.7	
18	Увс	-	-	-	-	-	
19	Ховд	-	-	-	-	-	
20	Хөвсгөл	-	-	-	-	-	
21	Хэнтий	79.3	89.1	89.5	92.5	88.7	
22	НЭМГ	74.6	80.6	73.6	65.7	79.3	
	Нийт	83.1	82.9	83.8	81.8	80.6	

ХАВСРАЛТ 2. АМБУЛАТОРИОР ҮЙЛЧЛҮҮЛЭГЧДИЙН СЭТГЭЛ ХАНАМЖИЙН ТҮВШИН (АЙМАГ, НИЙСЛЭЛ)

	Аймаг	Үзүүлэлт						Ерөнхий сэтгэл ханамж
		Байгууллагын соёл	Эмнэлгийн мэргэжилтний ёс зүй, үйлчилгээний соёл	Тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдал	Удирдлага, зохион байгуулалт			
1	Архангай	70.6	72.0	74.3	73.1	72.6		
2	Баян-Өлгий	-	-	-	-	-		
3	Баянхонгор	82.5	66.6	76.6	84.0	75.0		
4	Булган	77.3	74.9	78.8	66.7	74.4		
5	Говь Алтай	90.5	96.0	96.2	94.7	94.4		
6	Говьсүмбэр	-	-	-	-	78.8		
7	Дархан	71.4	75.9	80.6	-	78.1		
8	Дорноговь	79.7	80.0	78.1	73.9	77.9		
9	Дорнод	79.8	84.1	78.0	86.0	81.9		
10	Дундговь	90.3	84.6	81.0	93.0	87.2		
11	Завхан	75.0	75.0	75.0	56.0	70.2		
12	Орхон	-	-	-	-	62.1		
13	Өвөрхангай	-	-	-	-	80.2		
14	Өмнөговь	83.0	85.4	84.5	84.0	84.2		
15	Сүхбаатар	-	-	-	-	63.2		
16	Сэлэнгэ	-	-	-	-	-		
17	Төв	77.9	81.6	77.2	74.6	77.9		
18	Увс	-	-	-	-	-		
19	Ховд	70.0	86.0	78.0	80.0	80.0		
20	Хөвсгөл	87.8	88.9	89.1	87.8	92.8		
21	Хэнтий	80.8	89.6	88.3	90.5	88.8		
22	НЭМГ	68.5	74.4	70.0	65.4	77.1		
	Нийт	79.0	81.0	80.4	79.3	79.0		

ХАВСРАЛТ 3. ЭМЧ, ЭМНЭЛГИЙН МЭРГЭЖИЛТНИЙ СЭТГЭЛ ХАНАМЖИЙН ТҮВШИН (АЙМАГ, НИЙСЛЭЛ)

	Аймгийн нэр	Үзүүлэлт										Ерөнхий сэтгэл ханамж
		Дэмжлэг удирдлага	Хүний нөөцийн хөгжих боломж	Эмнэлгийн мэргэжилтний ёс зүй, үйлчилгээний соёл	Байгууллагын соёл	Тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдал	Ажлын байрны аюулгүй, дэмжлэгт орчин					
1	Архангай	77.6	78.9	80.5	84.0	80.2	81.0	81.0			81.0	81.0
2	Баян-Өлгий	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
3	Баянхонгор	62.4	54.5	83.5	96.0	80.8	74.0	86.0			86.0	86.0
4	Булган	73.1	57.5	78.0	84.6	76.4	77.5	74.5			74.5	74.5
5	Говь Алтай	94.6	89.1	91.5	98.0	95.2	88.7	92.9			92.9	92.9
6	Говьсүмбэр	-	-	-	-	-	-	-			-	-
7	Дархан	79.1	74.7	81.9	86.1	74.9	71.2	82.4			82.4	82.4
8	Дорноговь	-	-	-	-	-	-	-			-	-
9	Дорнод	-	-	-	-	-	-	-			-	-
10	Дундговь	76.0	81.0	85.9	87.0	-	-	82.5			82.5	82.5
11	Завхан	56.0	62.5	68.7	56.0	50.0	50.0	57.2			57.2	57.2
12	Орхон	-	-	-	-	-	-	72.1			72.1	72.1
13	Өвөрхангай	-	-	-	-	-	-	58.3			58.3	58.3
14	Өмнөговь	91.0	85.0	83.9	89.0	88.0	89.0	87.7			87.7	87.7
15	Сүхбаатар	-	-	-	-	-	-	47.2			47.2	47.2
16	Сэлэнгэ	-	-	-	-	-	-	-			-	-
17	Төв	65.8	64.0	82.9	77.5	82.5	71.5	74.7			74.7	74.7
18	Увс	-	-	-	-	-	-	-			-	-
19	Ховд	80.0	90.0	88.0	86.0	88.0	90.0	90.0			90.0	90.0
20	Хөвсгөл	83.8	84.8	88.1	86.8	89.9	83.2	86.1			86.1	86.1
21	Хөвсгөл	80.1	94.7	83.0	89.9	89.5	85.4	87.1			87.1	87.1
22	НЭМГ	53.4	55.1	64.6	58.3	58.8	45.6	54.8			54.8	54.8
	Нийт	74.8	74.8	81.6	83.0	79.5	75.6	76.9			76.9	76.9

ХАВСРАЛТ 4. СЭТГЭЛ ХАНАМЖИЙН ЕРӨНХИЙ ТҮВШИН (АЙМАГ, НИЙСЛЭЛ)

	Аймаг		Стационари	Амбулатори	Эмч, эмнэлгийн мэргэжилтэн	Нийт хүний тоо	Ерөнхий сэтгэл ханамжийн дундаж
1	Архангай	Оролцсон хүний тоо	192	779	242	1213	76.3
	Хувь	Хувь	75.3	72.6	81.0		
2	Баян-Өлгий	Оролцсон хүний тоо				3750	85.9
	Хувь	Хувь					
3	Баянхонгор	Оролцсон хүний тоо	195	592	593	1380	81.5
	Хувь	Хувь	83.5	75.0	86.0		
4	Булган	Оролцсон хүний тоо	2966	1923	295	5184	79.3
	Хувь	Хувь	89.1	74.4	74.5		
5	Говь-Алтай	Оролцсон хүний тоо	496	1069	223	1788	94.4
	Хувь	Хувь	95.9	94.4	92.9		
6	Говьсүмбэр	Оролцсон хүний тоо	228			228	78.8
	Хувь	Хувь	78.8				
7	Дархан	Оролцсон хүний тоо	180	320	230	730	80.7
	Хувь	Хувь	81.6	78.1	82.4		
8	Дорноговь	Оролцсон хүний тоо				453	80.7
	Хувь	Хувь		77.9			
9	Дорнод	Оролцсон хүний тоо				4125	87.0
	Хувь	Хувь		81.9			
10	Дундговь	Оролцсон хүний тоо	2480	4240	876	7596	87.2
	Хувь	Хувь					
11	Завхан	Оролцсон хүний тоо	972		712	1684	67.4
	Хувь	Хувь	74.7	70.2	57.2		
12	Орхон	Оролцсон хүний тоо			640		71.4
	Хувь	Хувь	80.0	62.1	72.1		
13	Өвөрхангай	Оролцсон хүний тоо	610	2165	346	3121	69.25
	Хувь	Хувь	80.2	58.3			
14	Өмнөговь	Оролцсон хүний тоо	1617		920	2537	85.4
	Хувь	Хувь	84.3	84.2	87.7		
15	Сүхбаатар	Оролцсон хүний тоо	145	275	141	561	59.8
	Хувь	Хувь	69.0	63.2	47.2		

16	Сэлэнгэ	Оролцсон хүний тоо Хувь	286	279	586	1151	
17	Төв	Оролцсон хүний тоо Хувь	67 78.7	158 77.9	246 74.7	471	77.1
18	Увс	Оролцсон хүний тоо Хувь					
19	Ховд	Оролцсон хүний тоо Хувь	256 80.0		146 90.0	402	85
20	Хөвсгөл	Оролцсон хүний тоо Хувь		92.8	86.1	11448	89.45
21	Хэнтий	Оролцсон хүний тоо Хувь	968 88.7	1681 88.8	272 87.1	2921	88.2
22	НЭМГ	Оролцсон хүний тоо Хувь				29566	72.8
						80309	79.9
					Нийт дундаж		

